



МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл-Аудит, Баталгаажуулалт, Аутсорсингийн үйлчилгээ
Санхүүгийн тайлан гаргах, Бизнесийн зөвлөгөө өгөх

2011 он 01 сарын 17 өдөр

Дугаар № 29

Монгол улс Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг
Утас: 976-99069029
И-Мэйл: odonchimegt@cpa.mn
misheelod@yahoo.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

" ГЛОБ ИНТЕРНЭШНЛ " ТББ-ЫН ТЭРГҮҮН Х.НАРАНЖАРГАЛ Танаа

Бид " Глоб интернэшнл " ХХК -ийн 2010 оны 12 дугаар сарын 31 -ний өдрийн байдлаархи баланс, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон мэдэгдэхүйц нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх замаар залилан, алдааны улмаас илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах, үүсч болох материаллаг буруу үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

Аудиторын үүрэг хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах нь бидний үүрэг юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стардартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Цар хүрээ

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна. Тэдгээр эрсдлийн үнэлгээнүүдийг хийдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдал зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолуудын бодитой эсэхийг үнэлэх ажлууд багтана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлттэй хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр 2010 оны 12 дугаар сарын 31 - ний байдлаархи санхүүгийн байдал хийгээд үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн, зөв, бодитой илэрхийлэгдсэн байна



Тайлан бичсэн захирал.....Т. Одончимэг

Зохиолчдын холбооны байр 314 тоот

Утас: 99069029,96659029, 50059029